

# УСНЫ КОМПАКТ



**500,000 хүн/цаг аюулгүй, хөдөлмөрийн чадвар алдалтгүй ажилласнаа тэмдэглэв**



Улаанбаатар хотын ус хангамж жилд 50 сая орчим куб метрээр нэмэгдэнэ.



Дулааны цахилгаан станцуудын техникийн усны хэрэглээний 85 хүртэл хувийг дахин боловсруулсан усаар орлуулж, гүний цэвэр усны хэрэглээг жилд 18.0 сая хүртэл куб метрээр бууруулна.



Усны салбарын хууль эрх зүйн бодлого зохицуулалтыг сайжруулах, салбар байгууллагуудын чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Үргэлжлэл 3-р нүүрт

**Б.Батсүх: Усны Компакт бол ус хангамжийн салбарт сүүлийн 30 жилд оруулж буй хамгийн том хөрөнгө оруулалт**

Усны Компактын санхүүжилтээр Улаанбаатар хотын нийт ус хангамжийг нэмэгдүүлэх төслийн хүрээнд хэрэгжүүлж буй гурван гол төслийн нэг...

Үргэлжлэл 2-р нүүрт



## ТӨСӨЛ 1. УС ХАНГАМЖИЙН БАРУУН ЭХ ҮҮСВЭРИЙГ ШИНЭЭР БАЙГУУЛАХ ТӨСӨЛ

Төслийн хүрээнд Биокомбинат, Шувуун фабрик орчмын газрын доорх усны ордыг түшиглэн ундны усны хоёр шинэ эх үүсвэр, ус дамжуулах шугам хоолой, дэвшилтэт технологи бүхий Ус гүн цэвэршүүлэх үйлдвэрийг байгуулна. Төсөл хэрэгжсэнээр Улаанбаатар хотын ус хангамж жилд 50 сая орчим куб метрээр нэмэгдэх юм.



**Б.Батсүх: Усны Компакт бол ус хангамжийн салбарт сүүлийн 30 жилд оруулж буй хамгийн том хөрөнгө оруулалт**

“Өнөөдөр бид долоон эх үүсвэрээс жилдээ 58 сая метр куб ус олборлон унд, ахуйдаа хэрэглэж байна. 2016 оноос эхлээд эрдэмтэд, тэр дундаа Дэлхийн банкны усны нөөцийн 2030 байгууллага, АНУ-ын Мянганы сорилтын корпорацийн судлаач мэргэжилтнүүд одоо ашиглаж байгаа долоон эх үүсвэрийн нөөц дээр судалгаа хийсэн. Ингээд “2023, 2024 оноос эхлээд эх үүсвэрүүдийн нөхөн сэргээгдэх хэмжээ, хэрэглэж байгаа хэмжээтэйгээ нэг түвшинд ирэх нь. Үүнээс хойш нөхөн сэргээгдэж байгаа хэмжээ нь хэрэглээгээ гүйцэхгүй болох эрсдэл байна” гэсэн судалгааны дүгнэлт гарсан. Өөрөөр хэлбэл, Улаанбаатар хотыг ойрын хугацаанд ундны усны шинэ эх үүсвэрээр хангах зайлшгүй шаардлага үүсэж байна гэсэн энэ дүгнэлт гарсан үг. Үүнд үндэслээд Усны Компакт гэрээ

буюу Улаанбаатар хотын нийт ус хангамжийг нэмэгдүүлэх хөтөлбөрийг АНУ-ын Мянганы сорилтын корпорац, Монгол Улсын Засгийн газар хамтран хэрэгжүүлэхээр болсон. Усны Компакт маань АНУ-ын 350 сая ам.долларын буцалтгүй тусламж, Монгол Улсын Засгийн газрын 111.7 сая ам.долларын хөрөнгө оруулалт, нийтдээ 461.7 сая долларын санхүүжилтээр хэрэгжиж байгаа. Хөрөнгө оруулалтын дүн, бүтээн байгуулалтын цар хүрээгээрээ Монгол Улсын усны салбарт сүүлийн 30 жилд оруулж байгаа хамгийн өндөр хөрөнгө оруулалт юм. Хэдийгээр Улаанбаатар хотын усны хэрэглээ барилгажилт, хүн амын өсөлт гээд олон хүчин зүйлээс шалтгаалах боловч бид ямар ч байсан ойрын 30 жилдээ ундны усны хомсдолд орохгүй байх өндөр ач холбогдолтой төсөл хэрэгжиж байна.”

Түрүүч нь 1-р нүүрт

### Шувуун фабрикийн эх үүсвэрийн нийт шугам хоолойн угсралтын ажлын гүйцэтгэл 88.5%-д хүрэв

Шувуун фабрикийн эх үүсвэрийн ус цуглуулах 15.8 км, ус дамжуулах 6.3 км шугамын угсралтыг гүйцэтгэж, нийт шугам угсралтын ажил 88.5%-д хүрэв. Үүнээс 12.3 орчим километр шугам хоолойн гидравлик туршилтыг амжилттай хийж гүйцэтгээд байна. Газрын доорх усны эх үүсвэрийн хуудгууд, ус дамжуулах шугам хоолойн барилга угсралтын ажлын нэгдсэн багцын “Баран групп” компанийн хариуцсан ажлын нийт гүйцэтгэл 66.67%-д хүрсэн байна.

#### ТОВЧХОН:

- Ус гүн цэвэршүүлэх байгууламжийг 22-ын товчооны замтай холбох 2.5 км авто замын барилга угсралтын ажил 25.7%-ийн гүйцэтгэлтэй явж байна.
- Ус хангамжийн баруун эх үүсвэрийг шинээр байгуулах төслийн хүрээнд нийт 28 ажлын байр шинээр бий болохоос 24 нь Ус гүн цэвэршүүлэх үйлдвэрт ажиллах бөгөөд үйлдвэрт ажиллах 20 гаруй ажилтныг тоног төхөөрөмжийн угсралт суурилуулалтын шатнаас эхлэн сургаж дадлагажуулахаар төлөвлөж байна. Одоогоор УСУГ-аас таван хүн сонгож томилсон нь үйлдвэр дээрээ сургалтад хамрагдаж байна.

### Ус гүн цэвэршүүлэх үйлдвэрийн бүтээн байгуулалт 93.3%-д хүрлээ

Компакт гэрээний санхүүжилтээр барьж буй хоёр томоохон үйлдвэрийн нэг болох дэвшилтэт технологи бүхий Ус гүн цэвэршүүлэх үйлдвэрийн барилга угсралтын ажил 2024 оны 11 дүгээр сарын сүүлийн байдлаар 93.3%-д хүрч, тоног төхөөрөмжүүдийн суурилуулалтын ажил үргэлжилж байна. Уламжлалт цэвэрлэгээний байгууламжийн барилга 98.72%, Цэвэршүүлсэн усны сан болон насос станцын барилга 98.56%, Тунадас боловсруулах байгууламжийн барилга 97.32%, Цахилгаан/генераторын барилга угсралтын ажлын гүйцэтгэл 99.56%, Урвуу осмосын байгууламжийн барилга угсралтын ажлын гүйцэтгэл 73.22%-тай тус тус үргэлжилж байна. Мөн үйлдвэрийн гадна талбайн ажлын гүйцэтгэл 96.8%-д хүрэв.



### Биокомбинатын эх үүсвэрийн ус дамжуулах шугам хоолойн суурилуулалтын ажил бүрэн дуусав

Ус гүн цэвэршүүлэх үйлдвэрийн барилга угсралтын ажлын гүйцэтгэгч БНТУ-ын “МАПА Иншаат вэ Тиахарет” компанийн гэрээний нэмэлт өөрчлөлтийн дагуу гүйцэтгэж буй шугам хоолойн барилга угсралтын ажлын нийт гүйцэтгэл 79.22%-д хүрлээ. Энэхүү ажлын хүрээнд Ус гүн цэвэршүүлэх үйлдвэрээс нийслэлийн ус хангамжийн нэгдсэн систем хүртэл цэвэршүүлсэн ус дамжуулах нийт 7.4 км шугамхоолой суурилуулж ажлын гүйцэтгэл 78%-д хүрсэн бол Биокомбинатын эх үүсвэрийн ус дамжуулах шугам хоолойн суурилуулалтын ажил бүрэн дуусав. Үүнээс, 6.1 км шугамын гидравлик туршилтыг хийж гүйцэтгэсэн бөгөөд үлдсэн 2км шугамыг ирэх онд суурилуулахаар төлөвлөөд байна.



## ТӨСӨЛ 2. ХАЯГДАЛ УС ДАХИН БОЛОВСРУУЛАХ ТӨСӨЛ

Төслийн хүрээнд шинэ Төв цэвэрлэх байгууламжийн дэргэд Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэр (“ХУДБУ”) болон дахин боловсруулсан усыг “ДЦС-3”, “ДЦС-4” ТӨХК-ууд руу дамжуулах системийг барьж байгуулна. Төсөл хэрэгжснээр дулааны цахилгаан станцуудын техникийн усны хэрэглээний 85 хүртэл хувийг дахин боловсруулсан усаар орлуулж, гүний цэвэр усны хэрэглээг жилд 18.0 сая хүртэл куб метрээр бууруулах юм.

### Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалт 66%-тай үргэлжилж байна

Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын хүрээнд барьж байгуулж буй технологийн 9, бусад 8, нийт 17 байгууламжийн барилга угсралтын ажил 2024 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар 66%ийн гүйцэтгэлтэй үргэлжилж байна. Технологийн есөн байгууламжаас хаягдал ус хүлээн авах худгийн барилгын ажил бүрэн дууссан, шахуургын станц №1 53%, тогтворжуулах сан 73%, хөдөлгөөнт био реактор 54.4%, ламелла тунгаагуурын байгууламжийн барилгын ажлын явц 50.4%-ийн гүйцэтгэлтэй байгаа бол ширхэгт дүүргэгчтэй шүүлтүүрийн барилгын ажил 26%, халдваргүйжүүлэх сан 72%, шахуургын станц №2 48.4%, ус зайлуулах сангийн барилга угсралт 50.6%-ийн гүйцэтгэлтэй үргэлжилж байна. Технологийн есөн байгууламжийн барилга угсралтын ажлыг 2024 оны барилгын улиралд, туслах найман байгууламжийн барилга угсралтын ажлыг 2025 онд дуусгах төлөвлөгөөтэй ажиллаж байна.



### Дахин боловсруулсан ус дамжуулах систем, ДЦС-уудын өөрчлөлтийн ажил 63%-ийн гүйцэтгэлтэй байна

Хаягдал ус дахин боловсруулах төслийн нэг гол бүрэлдэхүүн хэсэг болох Дахин боловсруулсан ус дамжуулах систем, ДЦС-уудын өөрчлөлтийн ажил 2024 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар 63%-д хүрлээ. Барилга угсралтын ажлыг хоёр үе шаттай хэрэгжүүлж байгаа бөгөөд эхний үе шат буюу Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэрээс ДЦС-4 ТӨХК рүү дахин боловсруулсан ус дамжуулах 4.7 км шугам хоолойг угсарч суурилуулсан

бөгөөд тус ажил 96%-ийн гүйцэтгэлтэй үргэлжилж байна. Хоёрдугаар үе шатны ажлын хүрээнд Өргөлтийн насос станцаас ДЦС-3 ТӨХК хүртэлх шугам хоолойн барилга угсралтын ажил 65%-ийн гүйцэтгэлтэй байна. Дэлхийн олон улс оронд ус дамжуулахад ашигладаг уян ширмэн хоолойгоор шугам хоолойгоо тавьж байгаа бөгөөд үйлдвэрлэгч орны зүгээс дунджаар 100 жилийн баталгаа өгч байгаа юм.

### 500,000 хүн/цаг аюулгүй, хөдөлмөрийн чадвар алдалтгүй ажилласнаа тэмдэглэв

Дахин боловсруулсан ус дамжуулах систем, ДЦС-уудын өөрчлөлтийн ажлын бүтээн байгуулалтад оролцож буй туслан гүйцэтгэгч 30 компанийн 1200 гаруй ажилтан хөдөлмөрийн аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавьж, нийт 500,000 хүн/цаг

аюулгүй, хөдөлмөрийн чадвар алдалтгүй ажилласнаа тэмдэглэв. Энэ хугацаанд аюулгүй ажиллагааны 80 гаруй сургалтыг зохион байгуулж, 500 гаруй үзлэг шалгалтыг гүйцэтгэсэн байна.

#### ШИНЭ ТУРШЛАГА:

- Шугам хоолойн барилга угсралтын ажлын хүрээнд зургаан газар шугам хоолойн сүвлэгээний ажлыг хийж гүйцэтгэв. Ачаалал ихтэй замуудыг хааж сэтлэн нээлттэй ухлага хийхгүйгээр 1000 мм шугам хоолойг газар доогуур сүвлэж суурилуулсан нь Монгол Улсад анхны туршлага болсон юм.



### ТӨСӨЛ 3. УСНЫ САЛБАРЫН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТӨСӨЛ

Усны салбарын хууль эрх зүйн орчин, бодлого зохицуулалтыг сайжруулахад дэмжлэг үзүүлж, салбар байгууллагуудын чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн 5 дэд үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

#### Улаанбаатар хотын унд ахуйн усан дахь зэвийг бууруулах урт хугацааны төлөвлөгөө, зөвлөмж боловсруулна



Монголын МСС 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Газарзүй, геоэкологийн хүрээлэнтэй “Улаанбаатар хотын унд ахуйн усан дахь зэвийг бууруулах урт хугацааны төлөвлөгөө, зөвлөмж боловсруулах зөвлөх үйлчилгээ”-ний гэрээнд гарын үсэг зурлаа. Энэхүү зөвлөх үйлчилгээний хүрээнд Улаанбаатар хотын унд ахуйн усанд зэв үүсэж буй шалтгаан, тохиолдол, хамрах хүрээ, үзүүлж буй нөлөөллийн талаар иж бүрэн суурь судалгаа хийх, судалгаанаас гарах зөвлөмж дээр үндэслэн зэвийг бууруулах, усны чанарыг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, нийслэлийн удирдлага болон ашиглалтын байгууллагуудад хүлээлгэн өгөх юм.

#### Усны нийгмийн бодлого хэрэгжүүлэх олон улсын туршлага судлах цуврал вэбинар зохион байгуулав



Монголын МСС Усны салбарын тогтвортой байдлыг хангах төслийн Зардал нөхөх дэд үйл ажиллагааны хүрээнд Үндэсний Статистикийн Хороотой хамтран “Ус худалдан авах чадварын судалгаа”-г боловсруулж, үр дүнг нь усны салбарын гол оролцогч талуудад 2024 оны 7 дугаар сард танилцуулсан.

Тус ажлын хүрээнд усны нийгмийн бодлого, тодруулбал ус худалдан авах чадварын асуудалтай нийгмийн эмзэг бүлгийн өрхүүдэд чиглэсэн бодлого, хөтөлбөр олон улсад хэрхэн хэрэгждэг талаар туршлага судлах цуврал вэбинарыг АНУ-ын МСК-тай хамтран зохион байгууллаа. 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр зохион байгуулсан эхний вэбинарын зочноор АНУ-ын Калифорни мужийн Зүүн эргийн нийтийн аж ахуйн ашиглалт, үйлчилгээний төвийн Хэрэглэгч, олон нийтийн үйлчилгээ хариуцсан захирал Эндрю Ли болон Хэрэглэгчдийг дэмжих хөтөлбөрийн зохицуулагч Шерилин Тран нар оролцож, 1.4 сая гаруй оршин

суугчид ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээ үзүүлдэг тус байгууллага нийгмийн эмзэг бүлгийн хэрэглэгчдэд чиглэсэн бодлого, хөтөлбөрийг хэрхэн хэрэгжүүлдэг, зорилтот бүлгээ хэрхэн тодорхойлж, санхүүжилтийн асуудлаа хэрхэн шийдвэрлэдэг зэрэг олон асуудлаар туршлагаа хуваалцлаа. Вэбинарт Монголын усны салбарын 50 гаруй төлөөлөл биечлэн болон цахимаар оролцож, сонирхсон асуултаа хариулт авч, ярилцав.

#### Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх үйл ажиллагааг таниулан сурталчлах ажлыг эхлүүлэв

#### Нидерландын ус ашиглалтын байгууллагуудын ментор, экспертүүд мэдлэг туршлагаа хуваалцлаа



Усны ашиглалтын байгууллагуудын түншлэлийн хөтөлбөр (WOP)-ийн хүрээнд Нидерландын ус ашиглалтын байгууллагуудын 12 ментор, экспертүүд мэдлэг туршлагаа хуваалцахаар 10 дугаар сарын 30-аас 11 дүгээр сарын 23-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо хүрэлцэн ирж ажиллалаа. Энэ удаад байгууллагын манлайлал болон ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээний үндсэн 12 чиглэлээр УСУГ, ОСНААУГ-ын инженер, техникийн ажилтнуудыг чадавхжуулах сургалтуудыг зохион байгуулав.

Оролцогчид техникийн үндсэн сэдвүүдээс гадна төслийн удирдлага, манлайллын чиглэлээр олж авсан үнэ цэнтэй мэдлэг, ур чадварт суралцсан бөгөөд сурсан мэдсэнээ бусдадаа хуваалцан байгууллагынхаа үйл ажиллагаанд нэвтрүүлж, Улаанбаатар хотын ус хангамж, ариутгах татуургын системийг сайжруулахаар төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Монголын Мянганы сорилтын сан Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх үйл ажиллагааны ач холбогдлыг сурталчлан таниулах, мэдлэг, ойлголтыг түгээх зорилго бүхий зөвлөх үйлчилгээний гэрээг 2024 оны 10 дугаар сарын 3-ны өдөр Монголын Хэвлэлийн Хүрээлэнтэй байгуулсан юм.

Уг ажлыг эхлүүлэх оролцогч талуудын уулзалтыг 11 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгуулж, кампанит ажлын стратеги, арга зүй, төлөвлөгөөг танилцуулан оролцогч талуудаас санал зөвлөмж авлаа. Уулзалтад “Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн гишүүд, холбогдох төрийн байгууллагууд, мэргэжлийн холбоодын төлөөлөл оролцож, мэдээлэл харилцааны мэргэжилтнүүдтэй харилцан мэдээлэл, туршлага солилцсон ач холбогдол өндөртэй, үр дүнтэй уулзалт боллоо.



## Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх дэлхийн удирдагчдын дээд хэмжээний 29 дүгээр уулзалт (COP29)-д оролцлоо

Бүгд Найрамдах Азербайжан улсын нийслэл Баку хотноо 2024 оны 11 дүгээр сарын 12-22-ны өдрүүдэд болсон Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх дэлхийн удирдагчдын дээд түвшний 29 дүгээр уулзалт (COP29)-д Монголын Мянганы сорилтын сангийн Гүйцэтгэх захирал Э.Энхгэрэл, Байгаль орчны захирал Ц.Дашзэвэг нар оролцлоо.

Тус чуулга уулзалтын хүрээнд АНУ-ын Төрийн Департаментас зохион байгуулсан “Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй байдал: АНУ-ын Засгийн газрын дэд бүтцийн хөрөнгө оруулалтын шинэ жишиг” сэдэвт хэлэлцүүлэгт Монголын МСС-ийн Гүйцэтгэх захирал Э.Энхгэрэл оролцож, Улаанбаатар хотын уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах чадавхыг бэхжүүлэхэд Усны Компактын оруулж буй хувь нэмрийн талаар мэдээлэл хуваалцлаа.

## Улаанбаатар хотын нийт ус хангамжийг нэмэгдүүлэх хөтөлбөрийн суурь судалгааны үр дүнг танилцуулав



Мянганы сорилтын II Компакт гэрээ буюу Усны Компактаар хэрэгжүүлж буй Улаанбаатар хотын нийт ус хангамжийг нэмэгдүүлэх хөтөлбөрийн суурь судалгааны үр дүнг гол оролцогч талуудад танилцуулах уулзалт 2024 оны 11 дүгээр сарын 1-ний өдөр боллоо. Уулзалт хэлэлцүүлэгт хөтөлбөрийн гол оролцогч талууд болох Сангийн яам, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газар, Ус сувгийн удирдах газар, Усны үйлчилгээг зохицуулах хороо (ХСУХАТАҮЗХ), Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, ДЦС-III болон ДЦС-IV ТӨХК-ийн төлөөлөл оролцов. Талууд суурь судалгааны үр дүн, түүнчлэн Компактын хэрэгжилтийн сүүлийн жилд гарч болох гол эрсдэлүүдийн талаар санал солилцож, хэлэлцүүлэг өрнүүлээ.

## Байгаль орчны залуу манлайлагчдад Усны Компактын мэдээлэл хуваалцав




Монголын Мянганы сорилтын сангийн Усны салбарын тогтвортой байдлыг хангах төслийн захирал Л.Өнөржаргал Зориг Сангаас 9 дэх жилдээ зохион байгуулж байгаа “Орон нутгийн байгаль

орчны манлайлал” хөтөлбөрийн оролцогчдод Усны Компактын хүрээнд хэрэгжүүлж буй Улаанбаатар хотын нийт ус хангамжийг нэмэгдүүлэх хөтөлбөрийн талаар дэлгэрэнгүй танилцуулж, усны салбарт тулгамдаж буй асуудлуудыг хэрхэн шийдвэрлэж буй талаар мэдээлэл хуваалцлаа. Байгаль орчны чиглэлд ажиллах, орон нутагтаа эерэг өөрчлөлт авчрах зорилгоороо шалгарсан 21 залуу манлайлагч Улаанбаатар хотноо хүрэлцэн ирж, тус хөтөлбөрт хамрагдаж байна. Монголын МСС нь энэхүү хөтөлбөртэй 5 дахь жилдээ хамтран ажиллаж байна.



Компакт гэрээ хэрэгжиж дуусахад



хугацаа үлдлээ